

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ**  
/эхний 10-р сарын байдлаар/

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 9.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 25.8 хувиар биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буюу 17.7 хувиар дээгүүр байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 7.2 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 0.1 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 46.8 тэрбум төгрөгт хүрсэн нь 2011 оны жилийн эцсээс 11.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 21 тэрбум төгрөг болсон нь 2011 оны жилийн эцсээс 4.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Ургац хураалт, хадлан бэлтгэл: Төмс 64.51 га-д, хүнсний ногоо 23.67 га-д, тэжээлийн ургамал 42.3 га-д тариалалт хийж, төмс 683.2 тн, хүнсний ногоо 223.1 тн, тэжээлийн ургамал 99.8 тн-ыг тус тус хураан аваад байна. Энэ оны хураан авалт өнгөрсөн оноос төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тус тус дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Байгалийн хадлан 11.4 мян.тн, гар тэжээл 0.7 мян.тн тус тус бэлтгэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс байгалийн хадлан 5.7 хувиар дээгүүр, гар тэжээл 6.1 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 25.6 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 2.6 тэрбум төгрөгөөр дээгүүр, оны үнээр 109.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 24.7 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, ул боов, зайрмаг, нүүрс, цайрын баяжмал, блок болон ихэнх төмөр эдлэлийн үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна. Энэ сард бууз, банш, хайрганы үйлдвэрлэлт нэмэгдэж орсон байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 10-р сард өмнөх 2011 оны жилийн эцсийнхээс 8.9 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана мах махан бүтээгдэхүүн 39.8 хувиар, жимс, жимсгэнэ 27.2 хувиар, мөн согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ, хувцас, бөс бараа, гутал, боловсролын үйлчилгээ зэрэг бүлгүүдийн үнэ өссөн байна.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** Эхний 10 сард 1071 эх амаржиж, 1082 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 523 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 26-аар олон байгаа бөгөөд вируст гепатит, тэмбүү, трихоминиаз, гахай хавдар, салхинцэцэг зэрэг өвчлөлүүд өссөн байна.


**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 815 болж урьд оны мөн үеэс 78 хүнээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 74 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 25.3 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 39.4 хувь нь бүрэн дунд, 6.5 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 10 сард 1260 хүн шинээр бүртгүүлж, 1073 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 517 хүн ажиллаж байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** : Эхний 10 сард 204 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 16-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 38 хүн нас барж, 62 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 182.9 сая төгрөгийн хохирол учирсны 169.9 саяыг нь нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 166 хүн холбогдон сэжиглэгдсэний 31.9 хувь нь согтуугаар, 10.8 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 2760 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 368 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 135 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС